

**“Гунан наст Мэхэлээ” туулийн тархац,
уламжлалын асуудалд**

Түдэвийн БАЯСГАЛАН*
Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Аман зохиол судлалын салбар

Received: Jul 07, 2024

Revised: Aug 08, 2024

Accepted: Sep15, 2024

Хураангуй: Энэ өгүүлэлд судлаачид ганц хувилбарт тууль гэж үзсээр ирсэн “Эрийн сайн гунан настай Мэхэлээ” гэдэг туулийг судлаад, уг тууль нь ойрад, халхуудын дунд өргөн дэлгэрсэн олон хувилбарт тууль болохыг тогтоожээ. Тус туулийн долоон хувилбарыг тогтоож, хувилбар тус бүрийн гарлыг тодруулахыг эрмэлзжээ. Анх дайн тулааны сэдэвтэй үүссэн тус тууль нь XIX зууны сүүл үед дайн тулаан, баатарлаг гэрлэлтийн хосолмол сэдэвтэй, ах дүү баатруудын алдар гавьяаны тухай мөчлөг (cycle) туулийн хэлбэртэй болжээ. XX зуунд тэрхүү хөгжсінгүй хэлбэртэй хувилбаруудын үйл явдлыг харилцан адилгүй түвшинд хадгалсан, ихэвчлэн товчхон өгүүлэгдэхүүнтэй аман хувилбарууд уламжлагдсан байна.

Түлхүүр үг: Хатан хурмаст, тууль хайлах, өрсөлдөгч, Хөхөө дэглэн

**Issue of the Tradition and Distribution of the Epic
“Tree Years Old Mekhelee”**

BAYASGALAN Tudev
Department of the Folklore studies, Institute of Language and
Literature, Mongolian Academy of Sciences, Mongolia

Abstract: In this article, it was discovered that the epic “The Best Hero Three Years Old Mekhelee” previously considered a single-version epic, is actually a multi-version epic widely popular among the Khalkha and Oirat people. Seven dis-

* © Т.Баясгалан
Email: bayasgalant@mas.ac.mn

inct versions of this epic have been identified, and the origins and traditions of each version have been described by the author.

The epic “The Best Hero Three Years Old Mekhelee” originated in ancient times, rooted in the mythic traditions of heroes who descended from the sky to establish peace on Earth. It features a war-themed narrative focused on regaining what was lost. By the late 19th century, among the Khalkhas and Western Mongols, it evolved into a cyclical epic with the following general storyline:

- 1) *The main hero, Mekhelee, chases Kharhurmugchin, who took away his herds and horses, to his homeland and kills him,*
- 2) *Upon returning home, Mekhelee goes after the five monsters who have invaded the deserted hinterland capturing his parents, servants and horses,*
- 3) *He wins the hand of the fairy Tolzandan, the daughter of king Todorkhoia-Yalgasan, who lives in the direction of the rising sun, after defeating her in the three games of men.*

The version by Sarisan and G. Dugersuren is proof that the most developed version of this epic was passed down to the people of Khalkha and Oirad in the same form. Epic singers from the Derbet ethnic group (Baglai, Khainzan, Zodov) verbally passed down brief or condensed versions, meanwhile the epic began to be fade from Khalkhas, although both directly relate to the same developed form mentioned above. Consequently, as the epic continued to be passed down orally, new versions emerged, diverging significantly in themes and events from the original source.

Key words: *Brave Sky, epic telling, contender, Khukhuu deglen*

Оросын газар зүйч, угсаатны зүйч, аман зохиол судлаач Г.Н.Потанин 1876-1880 онд Монголын баруун хойд нутгаар хээрийн шинжилгээний ажил хийж явахдаа дөрвөд туульч Сарьсанаас¹ “Эрийн сайн гунан настай Мэхэлээ”² (Иринь-Сайнь-Гунын-Настай-Мекеле) гэдэг туулийг тэмдэглэн авч, орос хэлээр орчуулан “Баруун хойд монголын тэмдэглэл” (1883) номын 429-486-р талд нийтлүүлжээ.

Г.Н.Потанин 1879 онд Улаангомд Сарьсантай анх уулзаж, Ховд явж ирэх хооронд “Эрийн сайн” туулийг тэмдэглэхээд байж байгаарай гэж цаас үлдээгээд, мөнгө өгнө гэж амлажээ. Тэр үед Сарьсан жар орчим настай, монгол бичиг сайн мэддэг хүн байсан гэнэ. Сарьсан тэгье гээд хоцорсон боловч Потаниныг эргэж ирэхэд юу ч бичээгүй байжээ. “Эрийн сайн” гэдэг туулийг Сарьсан долоо хоног хайлдаг юм санжээ (Монгол тууль: Товч толь. 2013: 166). Энэхүү Сарьсан нь 1869 оны үед М.Парчинд “Бум-Эрдэнэ” туулийг зааж сургасан Буурал Сэсрэн мөн байх гэж профессор Ц.Өнөрбаян таамаглаад

¹ Судлаачид Сарисан, Сарьсан гэж хоёр өөрөөр бичжээ. Энэ нь арьс, сарьс гэсэн утгатай үг бөгөөд үсгийн дүрмийн тольд “сарьс” гэж журамласан тул Сарьсан гэж жигдэлж авав.

² Мэхэлэ (mekele) гэдэг энэ үгийг академич Д.Цэрэнсодном “мэлхий” гэдэг үг гэж үзжээ [Цэрэнсодном, 2008: 34]. Энэ саналыг дэмжиж байна. Мэлхий гэдэг үгийг Шинжааны Жангарт “мэхэлэй” (mekelei) [baayanool-un jangar III. 2015: 339] гэж бичжээ. “Мэхэлээ” гэдэг үгийн к, л хоёр авианы байр ээлгэснээс “мэхлээ” гэдэг хэлбэр үүссэн бололтой. Энд Мэхэлээ гэж жигдэлж бичлээ.

Сарьсаны долоо хоног хайлдаг байсан “Эрийн сайн” гэдэг нь уг туулийн бүрэн нэр биш, “Эрийн сайн Хан Харангуй” юм уу, “Эрийн сайн Бум-Эрдэнэ” хоёрын аль нэгнийх нь товч нэр бололтой. Ингэж үзвэл, Сарьсан, Сэсрэн нарын мэддэг тууль нь ч адил байна (Өнөрбаян, 1998: 420-421) гэжээ.

Потанины нийтлүүлсэн “Эрийн сайн гунан настай Мэхэлээ” туулийг доктор (Ph.D) А.Алимаа монгол хэлээр орчуулж “Аман зохиол судлал” цувралын 2018 оны XXXIX ботид хэвлүүлсэн болно. Энэ орчуулгыг баримталж үзвэл, туулийн эхэнд гол баатрын нутаг орны магтаалтай, баатрын морь эмээллэх, даахь үргээх тэргүүтнийг дэлгэрэнгүй зураглан тоочиж өгүүлсэн тууль байжээ. Үүгээрээ өдгөө бидэнд уламжлан ирсэн баяд, урианхайн томоохон туулиудтай төстэй юм.

Юуны өмнө энэ тууль агуулга, үйл явдлын хувьд цор ганц тууль уу, эсвэл олон хувилбарт тууль уу гэдэг асуулт гарч ирнэ. Доктор (Ph.D), дэд профессор Р.Нарантуяа тус туулийг “Монгол туулийн бүртгэл” бүтээлдээ “Баяд, дөрвөдөд яригдсан ганц хувилбарт туулиуд” гэдэг гарчгийн дор Н.Н.Поппе Увс аймгийн Улаангом сумын дөрвөн (?) туульч Сарьсанаас тэмдэглэжээ (Нарантуяа, 1988: 127) гэж бичсэнээс үзэхэд ганц хувилбарт тууль гэж үзсэн нь илт байна. Харин Г.Н.Потаниныг андуурч Н.Н.Поппе гэжээ.

Миний зүгээс монгол туулийн сан хөмрөгийг шүүрдэж уншаад, “Эрийн сайн гунан настай Мэхэлээ” тууль бол ганц хувилбарт тууль биш, харин дөрвөд, халхуудын дунд хэдэн хувилбараар дэлгэрсэн олон хувилбарт тууль гэж тодорхойлов. Тус туулийн дараах хувилбарууд байгааг тогтоолоо. Сарьсаны хэлсэн “Эрийн сайн гунан настай Мэхэлээ” туулийг:

- 1) Увс аймгийн Бөхмөрөн сумын харьяат, дөрвөд туульч Цагаадайн Зодов “Хан сайхан Мэхлээ” гэдэг нэртэйгээр (Зодов, 2016: 155-215);
- 2) Мөн туульч Цагаадайн Зодов “Хангал ташаа хар хээр морьтой Хаан царигийн³ өвгөн” гэдэг нэртэйгээр;
- 3) Мөн туульч Цагаадайн Зодов “Хил хөх морьтой Хүйтэнзориг ноён” гэдэг нэртэйгээр;
- 4) Увс аймгийн Улаангом сумын харьяат дөрвөд туульч Чогсомын Баглай “Гурван зуун далан долоон нас хүрсэн өвгөн Цагаандалай хааны хөвгүүн гунан настай Мэхэлээ” гэдэг нэртэйгээр (Цолоо, 2013: 57-61);
- 5) Дорноговь аймгийн Өргөн сумын харьяат Гончигийн Дүгэрсүрэн (эм, халх) “Хөхөө Дэглэн” гэдэг нэртэйгээр (Цолоо, 1982: 41-49);
- 6) Дундговь аймгийн Баяндэлгэр сумын шуудан хүргэгч Аюуш овогтой Өвгөн “Хөхөө Дэглэн” гэдэг нэртэйгээр (Цолоо, 2013: 326) тус тус хэлжээ. Энэ тууль хэвлэгдээгүй учраас судалгаандаа ашиглаж чадсангүй.

³ Энэ үгийг олонх судлаач “цэргийн” (soldier, military) гэж бичжээ. “Цэргийн өвгөн” гэдэг нь ойлгомжгүй мэт. Миний бодоход, тэнхээ, тамир гэсэн утгатай “цариг” гэдэг үг болов уу. Мал сүрэг онд хүч таргатай орохыг монголчууд мал царигтай орлоо гэж ярьдаг. “Цариг цагаан ингэний сариг цагаан ботго” гэдэг нэртэй үлгэр бий. “Хаан царигийн өвгөн” гэдэг нь хаан цол хэргэмтэй, хүч чадалтай өвгөн гэсэн утгатай. Мөн “Гэсэр” туужийн баатар Царгин өвгөний нэрийг бяцхан сунжруулж хэлэхэд “царигийн” гэдэг дуудлагатай болохыг ч анхаарах хэрэгтэй. Энд царигийн гэж жигдэлж бичлээ.

- 7) Монголч эрдэмтэн Г.Рамстедт халх нутгаас “Гурван настай Гунаан хар Мэхэлээ” туулийг тэмдэглэн авсан нь “Умард монголын аман зохиол” (1973) номд авианы галиг үсгээр нийтлэгджээ (Ramstedt, 1973: 211-237).

Дээрх туулиудаас үзвэл, тус тууль дөрвөдөд олон хувилбартай, уртхан хэлбэр хэмжээтэйгээр дэлгэрч, халхад богино хэлбэрээр дэлгэрсэн байна. Профессор Ж.Цолоогийн сурвалжилснаар Увс аймгийн Малчин сумын иргэн, баяд туульч Рэнцэний Лхагва “Хан Харангуй” бол долоон бүлэг морин үлгэр бөгөөд тавдугаар бүлэг нь “Гулз хааны хөвгүүн Гунаан улаан Мэхлээ” гэдэг хэмээн хэлсэн байна. Энэ бүлэг нь энд авч үзэж буй “Гунаан наст Мэхлээ” тууль мөн бололтой. Гэхдээ Р.Лхагвын нэрлэсэн долоон бүлгийн нэрээс үзэхэд тэрбээр баядуудын дунд тус тусдаа хэлэгддэг бие даасан өөр туулиудыг “Хан Харангуй”-н бүлгүүд мэтээр ойлгож ярьжээ. Үүнээс үзэхэд, тус туулийг баядын туульчид хайлдаг байжээ.

“Гунаан настай Мэхэлээ” туулийн дээрх хувилбаруудыг харьцуулж үзэхэд хамгийн бүрэн бүтэн, дэлгэрэнгүй агуулгатай нь Сарьсаны хэлсэн хувилбар мөн байна. Гол баатар ба түүний сөргөлдөгч дүрийн нэрийг авч үзэхэд доорх хэлбэртэй.

№	Хувилбарууд	Гол баатрын нэр	Сөргөлдөгчийн нэр
1	Сарьсан	Мэхэлэ (mekele)	Хатан хар Хурмугчин
2	Ч.Баглай	Мэхэлэ (mekele)	Хатан Хурмаст
3	Ц.Зодов	Мэхлээ	Хотон хаан Хурмагч (заримдаа Хотон Хурмаст)
4	Г.Дүгэрсүрэн	Мэхээлэй	Хортой Хормогчин
5	Г.Рамстедт	Мэхилэ (mexilē)	Улаадай мэргэн

Дээрх хүснэгтээс үзэхэд ам дамжин уламжлах явцад гол баатрын сөргөлдөгчийн нэр бяцхан өөрчлөгдөж байжээ. Харин гол баатрын нэр бол авианы дуудлагын бяцхан өөрчлөлтийг эс тооцвол үндсэндээ өөрчлөгдсөнгүй. Ингээд дээрх туулиуд үнэхээр нэг туулийн хувилбарууд мөн эсэхийг нотлохын тулд тус бүрийн агуулгыг авч үзье.

Сарьсаны хувилбар

Гурван ерөнхий үйл явдлаас бүрдэнэ. Тэдгээр нь: 1) Мэхэлээ хүү нутагт нь довтлон ирж, адуун сүргийг нь хөөж явсан Хархурмугчины араас нутагт нь очиж устгасан, 2) Мэхэлээ буцаж ирээд эзгүй хойгуур нь довтлон ирж эцэг эх, албат ард, адуу малыг нь олзлон авч явсан ах дүү таван мангасын араас нэхэн очиж устгасан, 3) Мэхэлээ наран ургах зүгт байдаг Тодорхой-Ялгасан хааны охин Тользандан дагиныг эрийн гурван наадамд ялж эхнэрээ болгосон тухай болно. Дээрх гурван мотивын хүрээнд өрнөх үйл явдлыг товчоолбол:

1. Өндөр настай Мөнхтүргэл хаан, Энхтүргэл хатан хоёроос Мэхэлээ хүү төрөөд, 15 нас хүрээд аянд мордоно гэж зүтгэсэн. Адуучин өвгөн хангал ташаа хар хээр морийг хүүд барьж өгсөн. Хүүгийн дахийг үргээж, нэр

- өгөх ёслолын найр хийхэд, Мэхэлээ согтож унасан ба тэр хойгуур эцэг, эх нь морийг нь сул тавьж явуулсан
2. Хардай хааны хүү Хатанхархурмугчингэгч Мэхэлээгийн ах Хүйтэнзэвийг байлдан хөнөөж, Нагилгангоо хатныг нь олзлон авч явсан
 3. Хархурмугчин Мэхэлээгийн нутагт довтлон ирж, адууг нь хөөж явсан ба адуун доторх хангал ташаа хар хээр морь зугтаах гэж элдэв зүйлд хувилж оролдоод, эцэст нь дөрвөн мөчөө тас харвуулж шархдаад үлдсэн
 4. Мэхэлээ нойроос сэрээд, явган гарч алхсаар морио олж эмнэж эдгээж аваад, цааш Хархурмугчины нутагт очиж Гучин гурван хурмастын тусламжтайгаар Хархурмугчиныг дарж хөнөөсөн ба Хүйтэнзэвийн хоёр настай хүүд Хархурмугчины нутаг албатыг хариуцуулж нүүлгээд, өөрөө түрүүлж буцсан
 5. Мэхэлээ нутагтаа буцаж ирэхэд ах дүү таван хар мангас ирж, эцэг, эх, албат ардыг нь олзлон авч явсан байв. Мангасуудын араас очиж устгаж дараад, алдсан бүх зүйлсээ буцааж авсан
 6. Нутагтаа буцаж ирэхэд, Хайванхархүрэм тэргүүтэй гурван баатар нутагт нь довтолж ирсэнтэй Хүйтэнзэвийн хоёр настай хүү тулалдаж байв. Мэхэлээ, хүү хоёр тэдгээр дайсныг дарж, дайсны нутаг албатыг олзлон авчраад, найр цэнгэл хийж, Хүйтэнзэвийн хүүд Хавхан шүдэн хайрт Хархөхөл гэдэг нэр өгсөн
 7. Мэхэлээ зүүн зүгт байдаг Тодорхой-Ялгасан хааны Тользандан дагиныг авахаар явж, Хан-Арзага гэдэг ууланд хүрэхэд, арван таван алд биетэй урт хөх чоно тааралдаж, чонотой таван жил тэмцэлдсэн. Гэтэл тэр чоно Мэхэлээгийн тэнгэр дэх төрсөн ах Хүйтэн-Арслан байжээ. Чонын дүрээр газарт бууж тэр нутаг орныг хортон дайснаас хамгаалж байсан нь тэр аж. Хурмаст тэнгэрээс гурван талтай аянгын сумны нэг тал дээр энэ тухай бичиж, тэр хоёрын дунд буулгасныг уншиж ах, дүү хоёр бие биеэ таньсан
 8. Мэхэлээг цааш явахад Хүйтэн-Арслан ах нь замд тохиолдох хоёр хон хэрээ, хоёр шулам эмгэн, том могой, шигүү хар шугуй, Мөсөн цагаан уул, 900 алд биетэй хөх бух, цагаан буур, хорт далайг хэрхэн давж гэтлэх арга ухааныг зааж өгсөн
 9. Мэхэлээ ахынхаа зөвлөж захисан ёсоор замд тохиолдсон саад бэрхшээлүүдийг давж гарсаар Тодорхой-Ялгасан хааныд очиж, Догшинхархүрэл гэдэг баатартай эрийн гурван наадмаар мөрийцөж дийлээд, Тользандан дагиныг авах гэхэд, Тодорхой-Ялгасан хаан “Тэнгэр, газрын заагт нэг хар буур хэвтэж байгааг босгож авчраад сүрэгт минь нийлүүлж өг” гэсэн даалгавар өгснийг биелүүлээд Тользандан дагиныг аваад нутагтаа ирсэн
 10. Таван жил болоход Тользандан дагинаас хүүхэд гарсангүй. Үүний учрыг далан жил ном бясалгасан Дамбацагаан гэдэг ламаас асуухад, Эрлэгийн арван найман тамыг шүүж суллавал, үр хүүхэдтэй болно гэжээ. Мэхэлээ

явж Эрлэгийн арван найман тамын амьтдыг суллаад буцаж ирэхэд, нэг хүү төрсөн. Хүүг гурван нас хүрмэгц Хүйтэнхардөш гэдэг нэр өгч, амар сайхан жаргасан.

Энэ туулийг Потанин товчилж орчуулсан болох нь Хайванхархүрэм тэргүүтэй баатруудын довтолгоо зэрэг үйл явдлын хэсгүүдээс мэдэгдэхээс гадна уран яруу чимэг үгээр баялаг байсныг орос хэлээр орчуулахад бэрхшээлтэй тул тэр хэмжээгээр товчлогджээ. Туулийн уг эх нь лавтайяа дөрвөөс таван мянган шад шүлэгтэй байжээ.

Туулийн өгүүлэгдэхүүнээс үзвэл, Мэхэлээ хүү нутагт нь довтолж ирсэн Хатанхурмагчиныг даран сөнөөсөн тухай үйл явдал тус туулийн үндсэн (анхдагч) өгүүлэмж болно. Харин “там сулласан” тухай үйл явдал бол буддын шашны нөлөөгөөр монголчуудын дунд дэлгэрсэн Эрлэгийн орны тухай өгүүлэмжтэй холбоотой үүссэн байна. Тамын орны дүрслэл Молон тойн эхийнхээ ачийг хариулсан тухай үлгэрт гардаг бол 1716 онд хэвлэгдсэн Бээжин барын Гэсэрийн 7 дугаар бүлэгт Гэсэр хаан Эрлэгтэй тэмцэлдсэн тухай гардаг. Энэ уламжлалаар Гунан наст Мэхэлээ туульд Эрлэг тамын амьтдыг суллан чөлөөлсөн тухай үйл явдал нэмэгджээ.

Туулийн баатар үрийн хутаг гуйх зан үйл бол чухамдаа монголчуудын тэнгэр, газрын шүтлэг, эртний бөө мөргөлийн ойлголттой холбогдоно. Үрийн хутгийг ихэвчлэн тэнгэрт тэмээ сэтгэрлэх, газарт гахай сэтгэрлэх, эсвэл уулын тэнгэрийг тахиx зан үйл гүйцэтгэж буйгаар дүрсэлдэг. Гэтэл буддын шашны нөлөөгөөр тамд зовж тарчилсан амьтдыг суллан чөлөөлсний ач буянаар үр хүүхэдтэй болж буй тухай өгүүлэмж нь Гунан наст Мэхэлээ туульд барагцаалбал XVII зууны үед шинээр нэмэгдсэн байна.

Сарьсаны хэлсэн энэ хувилбар бусад хувилбарын үйл явдал ямар байдалтай уламжлагдсаныг тодруулахад чухал баримжаа болно.

Хөхөө Дэглэн

Г.Дүгэрсүрэнгийн хэлсэн энэхүү үлгэрийг дангаар нь уншвал үйл явдал нь ойлгомжгүй. Яагаад ойлгомжгүй байгааг Сарьсаны хувилбартай харьцуулж уншихад тодорхой болно. Учир нь, нэлээд мартагдаж үйл явдлууд энд тэндээсээ гээгдэж, үлдсэн үйл явдлуудыг үлгэрчийн зүгээс хооронд нь эмх замбараагүй холбож өгүүлсэн учраас ойлгоход бэрхтэй болжээ. Ямар үйл явдлууд мартагдав гэдгийг тодруулж үзье.

1. Сарьсаны хувилбарт Мэхэлэй хүүгийн даахийг үргээж, нэр өгөх ёслол үйлдэж найр наадам хийхэд Мэхэлэй архинд согтож унадаг. Энэ үйл явдлыг “Хөхөө Дэглэн”-д Мэхэлэй хүү хумхын чинээ хар батгана болж хувилаад тооноороо нисэн гарч явсан болгожээ (Цолоо, 1982: 44).
2. Сарьсаны хэлсэн “Эрийн сайн гунан настай Мэхэлээ” туулийн содон мотив нь адуутайгаа хамт дайсанд туугдаж явсан хангал ташаа хар хээр морь дайснаас мултарч үлдэхийн тулд цуцсан унага болж

хувирах, Элстэйн даваанд хүрч элс болж хувирах, Зостын даваанд хүрч зос болж хувилах, шигүү ой руу хөх марал болон хувилж орох, тарвага болон нүхэнд шургах, үнэг болж хувилаад зугтах зэргээр оролдоод, эцэст нь хар эрээн харцага шувуу болж тэнгэрт хөөрөхөд Хархурмугчин дөрвөн хөлийг нь тас харваж, морь цусаа урсгасаар хэвтэж үлддэг (Цолоо, 2018: 234-235). Энэ үйл явдал бүхэлдээ “Хөхөө Дэглэн”-д мартагдаж, зөвхөн “унадаг сайхан хүлэг нь үхэж, яс нь цайсан байв гэнэ” (Цолоо, 1982: 44) гэдэг өгүүлбэр л үлджээ.

3. Сарьсаны хувилбарт Мэхэлээгийн ахыг Хархурмугчин хөнөөж, бэр эгч Нагилгангоог олзлон авч явсан тухай үйл явдал гардаг. Энэ үйл явдлын үлдвэр “Хөхөө Дэглэн”-д Мэхэлэй хүү жороо цоохор морьтныг дарж хөнөөсөн тухай үйл явдлын хэлбэрээр үлджээ (Цолоо, 1982: 46-47).
4. Сарьсаны хувилбарт Мэхэлээ хүү Хархурмугчиныг дарж сөнөөгөөд, нутагтаа буцаж ирэхэд нутаг орон, аав ээж, албат ардыг нь ах дүү таван мангас ирээд олзолж дээрэмдээд авч явсны араас нэхэн очиж чөлөөлдөг. Харин энэ үйл явдал “Хөхөө Дэглэн”-д үндсэндээ хадгалагджээ.
5. Сарьсаны хувилбарт Мэхэлээ хүү Тользандан дагинатай гэрлээд, таван жил болоход үр хүүхэд гарсангүй. Уулын агуйд далан жил ном бясалгасан Дамбацагаан гэдэг ламаас учрыг асуухад, арван найман тамыг шүүж чөлөөл гэдэг (АЗС, 2018: 268). Ламын хэлсэн ёсоор Мэхэлээ явж арван найман тамын амьтдыг чөлөөлж сулладаг.

Энэ үйл явдал “Хөхөө Дэглэн”-д Мэхэлэй хүү мангасыг хөөсөөр уулын хар өвгөнд аваачсанд,

Уулын хар өвгөн
Гурван алдын газраас сөгдөж,
Амрыг эрж мэндлээд
- Гурван настай Мэхэлэй хүү минь
Хаагуур хаагуур явав?
Хаанаас хаа хүрч явна? гэхэд,
- Олон таван үтгүй
Хүрэл тамыг суллаж, хорт мангасыг хийгээд
Шөнийн манаатай, өдрийн ташууртай байлга гээд

(Цолоо, 1982: 48) явсан тухай бяцхан мэдээлэл төдийхөн зүйл болж үлджээ.

“Там сулласан” буюу тамын амьтдыг суллан чөлөөлсөн тухай энэ өгүүлэмжийн ул мөр “Хөхөө Дэглэн”-д үлдсэнээс үзэхэд, тус хувилбарт Сарьсаны хувилбартай ижил Мэхэлээгийн гэрлэсэн, үр хүүхэд гаралгүй хэдэн жил болсон тухай үйл явдал байсан боловч огт мартагджээ гэдгийг мэдэж болно. Түүнчлэн “Хөхөө Дэглэн” тууль нь Мэхэлэйн нутагт Хортой Хормогчин довтолсон, Хормогчиныг нутагт нь очиж устгасан, Хормогчинд олзлогдсон ахынхаа эхнэрийг чөлөөлөөд эргэж ирэхэд, нутаг орон, эцэг эхийг нь ах дүү долоон мангас (Сарьсаны хувилбарт ах дүү таван мангас) дээрэмдэж

олзлоод явсан байсны араас мөрдөж очиж чөлөөлж авсан тухай томоохон өгүүлэгдэхүүн бүхий тууль байжээ. Гэтэл ам дамжин уламжлагдах явцдаа өм цөм мартагдаж, үлдсэн үйл явдлуудыг хооронд нь хүчээр холбож өгүүлсэн учраас “Хөхөө Дэглэн” тууль ойлгомжгүй болжээ.

Туулийн нэр “Хөхөө Дэглэн” гэдэг нь ч мартагдсанаас үүдэлтэй. Монгол тууль бол гол баатрын нэрээр, эсвэл түүний эцгийн нэрээр нэрлэгддэг. Энэхүү зүй тогтол алдагдсаны улмаас тууль эхэлдэг үгээр, эхлэл шүлгээр нэрлэгдсэн тохиолдол цөөнгүй. Жишээлбэл, “Алтай хайлах” нэртэй тууль угтаа “Эрийн сайн Хөлөг-Эрдэнэ” тууль боловч нэрийг нь мартсанаас туулийн өмнө хэлдэг Алтайн магтаалаар нэрлэжээ. Г.Дүгэрсүрэнгийн хэлсэн энэ тууль бол тууль эхэлж буй хоёр үгээр нэрлэгджээ. “Хөхөө дэглэн найгаад байдаг” (Цолоо, 1982: 41) гэснээс үзэхэд “дэглэн” гэдэг нь өвс ногооны нэр ажээ. “Хөхөө” гэдэг нь “хөх” гэдэг үгийг аялгуулан хэлэх явцад “-өө” нэмж дуудсанаас үүссэн болов уу. Үүнтэй ижил жишээ гэвэл ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт хадгалагдаж буй Говь-Алтай аймгийн Жаргалант сумын харьяат Шаалий овогтой Ладараас (нас 69, эр) 1977 онд соронзон хальсанд бичиж авсан “Нар сая” нэртэй тууль юм. Энэ тууль “Агын-Улаан хаан” гэдэг тууль боловч туульч Ладар нэрийг нь мартсанаас тууль эхэлж буй “Нар сая мандахад” гэх үгээр нэрлэсэн байдаг.

“Хөхөө Дэглэн” туулийг академич П.Хорлоо судлаад, одоогийн манай халхын өмнөд нутагт өргөн дэлгэрсэн “Хөхөө Дэглэн” тууль бол баруун монгол баядад хэлэгддэг “Гурван зуун далан долоон нас хүрсэн өвгөн Цагаандалай хааны хөвгүүн гунан настай Мэхэлэй” (энэ туулийг баядын нэрт туульч Баглай хэлжээ П.Х.) гэдэг туулиас дамжин уламжлагдсан нэгэн хувилбар туульс юм (Хорлоо, 1987: 115) гэжээ. Бид тус туулийн хувилбаруудыг харьцуулсан судалсны үндсэн дээр Г.Дүгэрсүрэнгийн хэлсэн “Хөхөө Дэглэн” тууль Баглайн хэлсэн дээрх хувилбараас салбарлаагүй, харин Сарьсаны хэлсэн хувилбар, эсвэл түүнтэй ижил төстэй нэгэн хувилбараас салбарласан гэж дүгнэж байна.

Баглайн хувилбар

Туульч Чогсомын Баглайн хэлсэн “Гурван зуун далан долоон нас хүрсэн өвгөн Цагаандалай хааны хөвгүүн Гунан настай Мэхэлэй” гэдэг туулийг Раднаасэд 1929 онд худам монгол бичгээр бичиж авсныг профессор Ж.Цолоо “Халхын аман бичгийн хэлний дурсгал” (2013) номдоо гэрэл зургаар нийтлүүлжээ. Энэ хувилбар нэлээд товчхон юм. Туулийн эхэнд өгүүлэгддэг Мэхэлэй хүүгийн эцэг Цагаандалай хааны нутаг ус, эд баялгийн тухай магтаал, үр хүүхэдгүй гуньхарсан зэрэг үйл явдлууд орхигджээ. Үйл явдлыг товчоолбол:

Эрдэнэжаргал гэдэг хатнаас Мэхэлэй хүү төрлөө гэдгийг Харгис хааны хүү Хатанхурмаст гэгч сонсоод, тэр хүүг бага балчир байхад нь хорооё гээд үй түмэн цэргээ дагуулаад, нутагт нь довтлон ирж, Мэхэлэйг алахаар харвасан ч сум нь үл даав. Арга ядахдаа адуу малыг нь хамж туугаад явжээ. Гэтэл адуун дотроо байсан хангал ташаа хар хээр морь үлдэж хоцрох гэж элдэв амьтан, эд юмсад хувилж нуугдах гэсэн ч баригдаж, эцэст нь дөрвөн туурайгаа тас

харвуулж, хэвтэж үлдэв. Мэхэлэй нойрноосоо цочин сэрээд, явган алхсаар үхлүүт шархтай хэвтсэн хар хээр морио олж авч, эмнэн эдгээгээд, Хатан хурмастыг хөөн очиж, тулалдаж хөнөөгөөд, адуу малаа авч нутагтаа буцан ирээд амар сайхан жаргадаг. Баглайн хэлсэн энэ хувилбар Зодовын хувилбартай ойр төстэй хувилбар байжээ.

Зодовын хувилбарууд

Увс аймгийн Түргэн сумын харьяат, дөрвөд овгийн туульч Цагаадайн Зодовоос 1984 оны 9 дүгээр сард Д.Цэрэнсодном, А.В.Кудияров нар “Хан сайхан Мэклэй” гэдэг туулийг, судлаач Б.Катуу 1984 онд “Хангал ташаа хар хээр морьтой Хаан царигийн өвгөн”, “Хил хөх морьтой Хүйтэнзориг ноён” гэдэг туулиудыг тус тус соронзон хальсанд бичиж авсан нь бүгд “Тунан настай Мэхэлэй” туулийн хувилбарууд мөн байна.

Гурван туулийг уншиж үзэхэд, “Хан сайхан Мэклэй”, “Хангал ташаа хар хээр морьтой Хаан царигийн өвгөн” туулиуд бол угтаа ижил үйл явдалтай, нэг туулийг хоёр өөр цаг үед хэлсэн хувилбарууд байхад, “Хил хөх морьтой Хүйтэнзориг ноён” тууль бол тус туулийн гол баатар Мэхэлэгийн ахын гэрлэлт, дайсандаа дийлдэж мөхсөн тухай агуулгатай тусдаа бүлэг бололтой байна. Тус бүрд нь авч үзье.

“Хан сайхан Мэклэй” ба

“Хангал ташаа хар хээр морьтой Хаан царигийн өвгөн”

Тус хоёр туулийг Ц.Зодов 1984 онд хайлжээ. Хоёр хувилбарыг тулгаж үзэхэд, үг хэллэг нэлээд зөрөөтэй. Үүнээс үзэхэд туульч Цагаадайн Зодов туулийг үгчлэн цээжилдэггүй, хайлах бүрдээ шинээр хэлдэг (өөрөөр илэрхийлдэг) мэргэжлийн туульч байжээ. Д.Цэрэнсодномын тэмдэглэж авсан “Хан сайхан Мэклэй” нь “Цагаадайн Зодовын хайлсан туулиуд” (2016) номд, Б.Катуугийн тэмдэглэж авсан “Хангал ташаа хар хээр морьтой Хаан царигийн өвгөн” тууль “Дөрвөд ардын тууль” (1996) номд хэвлэгджээ.

Б.Катуугийн хэвлүүлсэн нь илүү дэлгэрэнгүй буюу бүрэн бүтэн, Д.Цэрэнсодномын хэвлүүлсэн хувилбар туулийн эхний 600 шахам мөр шад орхигдсон буюу дутуу байна. Гэхдээ нэлээд товчлогдсон тууль болохыг тэмдэглэх хэрэгтэй.

Зодовын хувилбар нь: 1) Мэклэй хүү эхээс мэндэлсэн ба нутаг орон руу нь Хотон хаан Хурмагчин довтолж ирж, адуун сүргийг нь хөөж явсны араас балчир бага Мэклэй нэхэн очиж хөнөөсөн, 2) Хурмагчиныг дараад ирэхэд ах дүү долоон мангас аав ээж, ард түмнийг нь олзлоод явсны араас хөөж очиж устгасан, 3) Ах дүү гурван мангаст хөнөөгдсөн Цахирбодон хааны хүүг Мэклэй амь оруулж, гурван мангасыг дарж хөнөөсөн тухай ерөнхий өгүүлэгдэхүүнтэй.

1. Зодовын хувилбараас Мэклэгийн гэрлэлтийн үйл явдал ор мөргүй гээгджээ.

2. Сарьсаны хувилбарт Мэхэлээ нь Хан хурмастын гурван хүүгийн нэг бөгөөд тэд нь Хүйтэнзэв, Хүйтэн-Арслан, Мэхэлээ гурав болно. Тэгвэл Зодовын хувилбарт Мэклээг Хан хурмастын дөрвөн төмөр хүйстэй хүүгийн нэг гэжээ.
3. Сарьсаны хувилбарт гардаг Мэхэлээгийн ах болох Хүйтэнзэвийн эхнэр Нагилгангоогийн дүр Зодовын хэлсэн эхэд Мэклээгийн зулайг гишгэж төрсөн эгч болжээ.
4. Зодовын хувилбараас Мэклээгийн тэнгэрт байдаг ахын дүрүүд ба тэд энэ ертөнцөд бууж ирж хортон дайснуудыг дарах үүрэг гүйцэтгэдэг үйл явдлууд хасагджээ. Үүнтэй холбоотойгоор үлдэж хоцорсон зарим үйл явдлыг өгүүлэгдэхүүний бүтцэд тохируулан өөрчлөн найруулжээ. Тодруулбал, Сарьсаны хувилбарт Хүйтэнзэвийн хоёр настай балчир хүүгийн дүр гардаг. Мэхэлээ Хархурмугчиныг дарж хөнөөгөөд, адуу мал, албат иргэнийг нь энэ хүүд даатгаж нутаг руугаа нүүлгэдэг. Гэтэл замд нь Хайванхархүрэм тэргүүтэй баатар довтолсон тухай товчхон мэдээлэл бий (Потанин, 2018: 254). Энэ үйл явдлыг Зодовын хувилбарт төгсгөлийн бие даасан бүлэг болгож, ах дүү гурван мангаст хорлогдож сүнс нь зайлж одсон Цахирбодон хааны хүүг Мэклээ амилуулж, гурван мангасыг дарсан тухай бүлгийн (chapter) хэмжээнд (Зодов, 2016: 204-215) өөрчлөн найруулжээ.

Дүгнэхэд, Зодовын хэлсэн энэ хувилбар Сарьсаны хувилбараас салбарлаагүй. Харин Сарьсаны хувилбартай ижил түвшинд хөгжсөн өөр нэг хувилбараас салбарлажээ.

Хил хөх морьтой Хүйтэнзориг ноён

Энэ туулийг судлаач Б.Катуу туульч Цагаадайн Зодовоос 1984 онд соронзон хальсанд бичиж аваад, “Дөрвөд ардын тууль” (1996) номдоо хэвлүүлжээ. Энэ тууль бол Сарьсаны хувилбараас гаралтай бөгөөд амаар уламжлагдах явцдаа нэлээд хэсэг нь мартагдаж, үлдсэн үйл явдлуудыг туульчийн зүгээс хооронд нь залгаж эвлүүлж хэлжээ. Ингэснээр тус тууль баатарлаг гэрлэлтийн сэдэвтэй ондоо тууль болж хувирсан байна.

Туулийн гол баатрыг Хүйтэнзориг ноён гэдэг. Хаан царигийн өвгөний хүү Гунан наст Мэхэлээ гэдэг нэр яагаад тийнхүү хувирав гэдэг асуулт гарна. Сарьсаны хувилбарт Мэхэлээгийн нэг ах нь Хүйтэнзэв нэртэй, түүний хүүгийн нэрийг Хавхан шүдэн хайрт Хархөхөл гэдэг. Гэтэл Зодовын хэлсэн энэхүү туульд Хүйтэнзэв гэдэг нэр Хүйтэнзориг болж, Хавхан шүдэн хайрт Хархөхөл нь Хүйтэнзоригийн дүү болж хувирсан байна.

Энэ хувилбарт гарч буй Хүйтэнзоригийн гэрлэлт ба Догшин хаан хурмастад дийлэгдэж алагдсан үйл явдал нь угтаа Сарьсангийн хувилбарт дурдагддаг Хүйтэнзэв баатрын Хатанхурмугчинд хөнөөгдсөн тухай үйл явдлын бүрэн бүтэн хэлбэр мөн байх өндөр магадлалтай байна. Харин энэ туульд Мэхэлээгийн нэрийг Хавхан шүдэн хайрт Хархөхөлийн нэрээр сольжээ.

Энэ хувьсал өөрчлөлтийн үр дүнд Гунан наст Мэхэлээ туулиас уран сайхны боловсруулалтын явцад “Хил хөх морьтой Хүйтэнзориг ноён” гэдэг тууль шинээр үүссэн гэж дүгнэж болно.

Рамстедтийн тэмдэглэсэн хувилбар

Монголч эрдэмтэн Г.И.Рамстедт “Гурван настай гунан хар Мэхэлээ” гэдэг энэ туулийг XX зууны эхэн үед халх монголоос эрдэм шинжилгээний галиг үсгээр тэмдэглэж авсныг түүний шавь Х.Хален “Умард монголын аман зохиол” (1973) номын 211-237-р талд хэвлүүлжээ. Энэ тууль үйл явдлын хувьд энд авч үзэж туулийн хувилбар гэхээс илүү бие даасан тууль болтлоо өөрчлөгдөн хувьсжээ.

Тус хувилбарт гол баатрын нэр Гунан хар Мэхэлээ (mexilē) гэж бараг өөрчлөгдөөгүй байна. Харин Мэхэлээ холын аянд унадаг дөнөн хөх борлог морьтой, ойрын аянд унадаг хангал ташаатай хар хээр морьтой (Ramstedt, 1973: 213) гэжээ. Хангал ташаатай хар хээр морьтой Гунан хар Мэхэлээ гэдэг алдар нэр нь тус туулийг энд судалж буй туулийн нэг хувилбар гэдгийг илхэн харуулна.

Уг туулийн үйл явдал нь: 1) Мэхэлээ хүү нутагт нь довтолж ирсэн урд зүгийг эзлэнхэн төрсөн Улаадаймэргэн хүүг угтан очиж дарсан, 2) Түрэмгийлэн довтолж ирсэн Барс арслан шинжтэй хааныг угтан очиж хөнөөгөөд, нутагт очиж эхнэрийг нь цавчтал, эрхийн чинээ хүрэл хүү гэдэснээс нь гарч ирснийг Улаадаймэргэн дүүтэйгээ хамжиж дарсан тухай үндсэн хоёр хэсэг үйл явдлаас бүрддэг.

Нэгдүгээр үйл явдал нь Гунан наст Мэхэлээ туулийн уугуул үйл явдалд төдийлөн холбогдохгүй. Хоёрдугаар үйл явдал нь Сарьсаны хувилбарт гардаг Мэхэлээгийн нутагт довтолж ирдэг Хархурмугчинтай байлдсан тухай үйл явдлын нэлээд мартагдсан хувилбар мөн байна. Энэ хэсэгт хангал ташаа хар хээр морь Хурхурмугчингаас зугтах гэж элдэв юмс, амьтанд хувилсан хэсэг, Хархурмугчингийн хатны гэдэснээс гарсан хүүтэй ноцолдож арай ядан дарсан, Мэхэлээгийн адуун сүрэг Хархурмугчины цэргүүдийг гишгэчиж алсан тухай үйл явдлууд нэлээд бүдгэрч өөрчлөгдсөн хэлбэрээр гарч байна. Г.И.Рамстедт уг туулийг Потанинаас хориод жилийн дараа халх нутгаас тэмдэглэж авчээ. Уншиж үзэхэд, Сарьсаны хувилбараас Рамстедтын хувилбар гаралтай гэж үзэх үндэслэл байхгүй. Тиймээс уг тууль халхуудын дунд XIX зуунаас нэлээд өмнө цаг үеэс амаар уламжлагдаж ирсэн байна.

Дүгнэлт

“Эрийн сайн гунан настай Мэхэлээ” тууль нь энэ ертөнцийг төвшитгөхөөр тэнгэрээс бууж ирсэн баатруудын тухай домгийн уламжлалын хөрс суурин дээр алдсанаа олж авсан тухай ерөнхий өгүүлэмжтэй дайн тулааны сэдэвт туулийн хэлбэрээр эрт үед үүсэж, XIX зууны сүүлч гэхэд халх, баруун монголчуудын дунд 1) Гол баатар Мэхэлээ хүү нутагт нь довтлон ирж, адуун сүргийг нь хөөж явсан Хархурмугчины араас нутагт нь очиж устгасан, 2) Мэхэлээ буцаж ирээд

эзгүй хойгуур нь довтлон ирж эцэг эх, албат ард, адуу малыг нь олзлон авч явсан ах дүү таван мангасын араас нэхэн очиж устгасан, 3) Мэхэлээ наран ургах зүгт байдаг Тодорхой-Ялгасан хааны Тользандан дагиныг эрийн гурван наадамд ялж эхнэрээ болгосон тухай ерөнхий өгүүлэгдэхүүн бүхий мөчлөг тууль болж хөгжжээ.

Тэрхүү хөгжсөн хэлбэр нь халх, ойрадад нэгэн адил уламжлагдсаны баримт нь Сарьсан, Г.Дүгэрсүрэн нарын хувилбар мөн. Тэрхүү хөгжсөн хувилбартай гарлаараа шууд холбоотой боловч нэлээд товчхон хувилбаруудыг дөрвөдийн туульчид амаар (Баглай, Хайнзан, Зодов) уламжлан дамжуулсан бол халхад мартагдаж эхэлсэн байна. Тийнхүү ам дамжин уламжлагдах явцад сэдэв, үйл явдлаараа анхдагч эхээсээ ихээхэн хувьсан өөрчлөгдсөн шинэ туулиуд үүсжээ.

Ном зүй

А. Монгол хэлээр:

Баянголын Жангар. III. (2015). *Хошууд, Бостнуур шианы боть*. Ерөнхий эрхлэн найруулагч Б.Мөнх, Ма Шиюн, Амжилт, Нарангоо. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо. [Bayangoliin Jangar. III. Yerunkhii erkhilen nairuulagch B.Munkh, Ma Shiyun, Amjilt, Narangoo [Jangar in Bayangol province]. Committee of Cultural printing in Inner Mongolia: 2015.]

Катуу, Б. (1996). *Дөрвөд ардын тууль*. Улаанбаатар: [Katu, B. Dörvöd ardiin tuuli [Derbet people's epics]. Ulaanbaatar: 1996.]

Катуу, Б., Алимаа А., Дайриймаа, Б., Заяасүрэн, Ч., Дулам, С., & Баясгалан, Т. (2013) *Монгол тууль: товч толь*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Katu, B., Alimaa, A., Dairiimaa, B., Zayasuren, Ch., Dulam, S., Bayasgalan, T. Mongol tuuli: tovch toli [Mongol epic: brief dictionary]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2013.]

Нарантуяа, Р. (1988). Монгол туулийн бүртгэл. *Аман зохиол судлал. XVIII*: 79-154. [Narantuya, R. Registration for Mongol epics. *Folklore Studies*. 1988, XVIII: 79-154.]

Өнөрбаян, Ц. (1998). *Туульч Парчингийн амьдрал, ур чадварын тухай зарим мэдээ*. Төв Азийн тууль. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК. [Unurbayan, Ts. Some news about the life and skills of the epic singer M.Parchin. *International symposium-Festival "Central Asian Epos"*. 417-426].

Потанин, Г.Н. (2018). Эрийн сайн гунан настай Мэхэлэй. *Аман зохиол судлал. XXXIX*: 223-272. [Potanin, G. N. Three years old best hero Mekelei. *Folklore Studies*. 2018. XXXIX: 223-272].

Хорлоо, П. (1987). *Ард түмэн, аман зохиол. Аман зохиолын тухай, судалгааны өгүүллийн эмхэтгэл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Khorloo, P. Ard tumen, Aman zokhiol [Khorloo, P. Folk and

Folklore]. Ulaanbaatar: State Publishing House. 1987.]

Цолоо, Ж. (1982). *Монгол ардын баатарлаг тууль*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Tsoloo, J. Mongol ardiin baatarlag tuuli [Tsoloo, J. Mongolian folk heroic epics]. Ulaanbaatar: State Publishing House. 1982.]


Цолоо, Ж. (2013). *Халхын аман бичгийн хэлний дурсгал*. Арван гурван сангийн орон цуврал. XV. Улаанбаатар: Адмон хэвлэлийн газар. [Tsoloo, J. Khalkhiin aman bichigiin khelnii dursgal [Examples of Khalkha's oral literary]. Ulaanbaatar: Admon printing. 2013.]

Цэрэнсодном, Д. (2016) *Цагаадайн Зодовын хайлсан туулиуд*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Tserensodnom, D. Tsagaadain Zodoviin khailsan tuuliud [Epics performed by Zodov Tsagaadai]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2016.]

Цэрэнсодном, Д. (2008). *Монгол туулийн эртний хэлбэр, түүний хувьсал хөгжлийг судлах арга барилын асуудал*. Монгол аман зохиол, утга зохиолын онол, түүхийн асуудал. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Tserensodnom, D. On the problem of methods of researching the ancient form of the Mongolian epic and its evolution. *Problems of Mongolian Folklore, literary theory and its history*]. Ulaanbaatar: Soyombo Printing. 2008: 31-38.]

Б. Гадаад хэлээр:

Nordmongolische Volksdichtung. Gesammelt von G.J.Ramstedt. Bearbeitet, Übersetzt und Herausgegeben von Harry Halén. Band I. Suomalais-Ugrilainen Seura. Helsinki, 1973. 287 p. ISBN 951-9019-05-7.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.